

## I. МОНГОЛЫН ЭРТНИЙ ТҮҮХИЙН АСУУДАЛ

### ЭРТНИЙ НҮҮДЭЛЧДИЙН СОЁЛЫН ЗАРИМ ДҮРСГАЛЫН УЧИР

Ю.Болдбаатар

ШУТИС, Хүмүүнлэгийн Ухааны сургууль, Түүх-Хүн судлалын профессорын баг.

**Өгүүллийн товч утга:** Энэ өгүүлэл гурван хэсгээс бүрдэх бөгөөд эхнийхт монголын хадны зурагт дийлэнх хувийг эзлэх адгуус амьтны дүрсийг тухайн үеийн урлаачид юуны учир урласан болохыг, удаахт эхний хийгээд гурав дахь хэсэгт өгүүлэх эртний зарим зан үйл, дом ёсны уялдаа, хамаарлыг, төгсгөл хэсэгт хүн чулуу буюу хөрөг чулуун хөшөөг үйлдэх болсон учир шалтгааныг тайлбарлахыг зорьсон болно.

**Түлхүүр үг:** Сүг, сүлд, сүнс, онгон, этүгэн, хөрөг.

#### Нэг. Хүрлийн үеийн хадны зураг дахь адгуус амьтдын дүрслэлийг тайлбарлах нь

Манай орны эртний судлалд нилээд хэвшил болсон хадны сүг зураг, хадны зураг сүг гэсэн нэр томъёо нь угтаа монголчуудын амийг тээгч сүнс, сүлдгүй биеийн дүрсийг нэрлэдгээс үүдэлтэй хийгээд "сүг" гэсэн эл үг нь хэдийгээр дүрс гэсэн утгатай төвд үг боловчиг, монгол хэлнээ орж, хэрэглэгдэх болсон цагаасаа сүлд, сүнс, сүүдэр гэх үгстэй утгын хувьд уялдаж сүлэлдсэн нь, монголчуудын окууны ертөнц дэх эдгээр үгсийн утгаар илрэн гардаг цогц ойлголтыг баяжуулсан ажгуу.

Сүг гэдэг үгийн утгын талаар Я.Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь" бүтээлдээ: 1. сүнс:сүг сүнс хорш. дүрс:хүний сүг, хий сүг (шашны ба нууц далдыг шүтэх ёсонд:биегүй мөртлөө сүрхий чадалтай амьтан мэт). сүг болох (машид турах, дөнгөж хүн төрх нь үлдэх), зураг сүг (хад чулуу зэрэг юманд сийлсэн аливаа дүрс зураг) /21;494/ гэж тайлбарлажээ.

Миний бие энэ үгийг эртний хүмүүсийн хад чулуун дээр үйлдсэн адгуус амьтдын холбогдолтой элдэв зураг сүгүүдийн зурах болсны цаад учир шалтгааныг нээн сурвалжлахуйд үнэтэй чухал түлхүүр болно хэмээн үзэж байна.

Бидний хоёр гурван үеийн урдах өвөг дээдэс хад чулуун дээр "Галав юүлэхэд ганцхан үлдэх юм хэмээн" бурханы шашны маанийн үсгийг цохьдог асан, өдгөө гээгдсэн ёсыг эс тооцвол байгалийн хад чулуун дээр адгуус амьтдыг дүрслэн зурдаг эртний ёс нэгэнт орхигджээ. Гэвч бурханы шашны үүднээс тайлбарлаж үл болох эртний нүүдэлчдийн бөө мөргөлтэй холбоо бүхий зарим нэг уламжлалт зан үйлд мал амьтадын дүрсийг хадан дээр бус газар зурж дүрсэлдэг ёс үлдэж хоцорсон байна. Тэрчлэн дархадын бөөгийн ёсонд онгодоо дуудаж ирүүлэхэд хөлөг унаа нь болох бугын арьсаар хийсэн хэнгэрэг дээр улаан зосоор тухайн бугын авлахын цагт ямар төрх байдалтай байсан тэрхүү байдлаар нь амьдчилж зурдаг ёс үлдэж хоцорчээ (3:210). Энэ бүхнийг бид судалгааны үндсэн эх сурвалжууд болгож байна. Үүнд:

1. 1995 онд Хөвсгөл аймгийн Чандмань Өндөр сумын харъяат 66 настай Готовын Цэдэвсүрэнгээс (өдгөө тэрвээр нас сүүдэр 74 хүрч байна.) Монголчуудын малын өвчнийг анагаах уламжлалт арга, мэдлэгийн талаар сурвалжилж байх үедээ доорх сонирхолтой мэдээг тэмдэглэн авсан юм.

Г.Ц. - Халуун нартай өдөр бага мал гэнэтхэн үхэтхийн унадаг юм. Үүнийг түүдэгтэх гэх бөгөөд шилбүүрний үзүүрээр газарт биеийг нь

тойруулж зураад, хамарт нь хоёр цагаан чулуу цохиж хавиран утааг нь үнэртүүлж, сүүлнийх нь үзүүрийг цус гартал хаздаг юм. Тэгээд л босоод ирнэ.

Ю.Б. -Яагаад газар дээр биеийг нь тойруулан зурж байгаа юм бэ?

Г. Ц. - Мэдэхгүй, газрын юм авчихлаа л гэдэг юм гэж билээ.

Энд өгүүлсэн газрын юм гэдэг нь газрын эзнийг хэлж буй нь илэрхий хийгээд бурхан шашны үүднээс авч үзвэл энэ нь уул, усны эзэн лус, савдаг болох боловч бурхан шашинд холбогдолтой зан үйл биш учраас монголчуудын газар усыг шүтэх язгуур шүтлэг дэх газрын эзэн онгон буюу этүгэн гэж ойлгох нь зүйтэй хэмээн үзэж байна.

2. Монголчууд бод мал, түүний дотор ихэвчлэн ингэ ботголох, үнээ тугалахад гарсан төлийг биеийнх нь хэлбэр дагуулж, тойруулан газарт зурж авдаг ёс саяханыг хүртэл байжээ. Энэ нь дээр өгүүлсэнтэй учир шалтгаан, утгын гүнзгий холбоотой эртний шүтлэг, зан ёсны улбаа болно.

3. "БНМАУ-ын угсаатны зүй боть 1"-д "Монголчууд ирвэс агнавал арьсыг нь газарт тавих цээртэй, өвчиж хуулахын өмнө биеийг нь тойруулан зурж, газарт заавал дүрсийг нь үлдээдэг ёстой" /6:394/ гэж өгүүлжээ. Энэхүү ёсыг доктор Д.Цэвээндорж "Энэ нь хангай дэлхий, ангийн эзэн (тэнгэр) эл амьтныг анчинд хайрлан түүнийг (сүнсийг) газар дэлхийд, нутагт нь зурж үлдээж зөвхөн арьсыг нь авч буй анчдын шүтлэгийн нэн эртнээс уламжлагдаж ирсэн ойлголтын хэлбэр юм" гэж тайлбарлажээ. Үүнтэй бид санал нэг байгаа боловч гагцхүү сүнсийг тэмдэглэсэн гэсэнтэй зөрж байгаа юм. Аливаа амьтны сүнс гэдэг нь эртний хүмүүсийн үзэл төсөөллөөр авч үзвэл мөнх бөгөөд тэнгэр огторгуйд оршиж, зарим тохиолдолд эргэн төрдөг. Иймээс түүнийг газарт зурж тэмдэглэн үлдээх учиргүй гэж бид үзэж байна. Харин газар зурсан тэрхүү сүг дүрсийг бид сүлд, сүнс нь халин одсон нэгэн биеийн буюу тухайн бодьгалын дүрс гэж үзэж байна.

4. Монголчуудад нэлээд түгээмэл нэг ёс бол хээрээс олсон үнэгийг газарт тойруулан зурж авдаг ёс юм. Үүнтэй холбоотой нэгэн мэдээг Баянхонгор аймгийн Баянбулаг сумын харъяат буурал ээж Г.Доосмаагийн амьд сэрүүн цагт буюу 1997-9-22-нд тэмдэглэн авснаа толилуулвал. (Тухайн үед буурал ээж маань 76 настай байв).

"Муу дүү дараа жил нь гарах дөхөөд нүгнээ уншуулах гэхэд лам нар баригдацгаагаад уншуулах лам олдохгүй байсан тэр жил (1937 оны улаагчин үхэр жил) манайх Өлийн өврийн Шар цохионд байсан юм. Би нэг өдөр урд талын Улаан шовход хонь харуулж яваад хонь үргээд байхаар нь очтол сайхан улаан үнэг үхсэн хэвтэж байсан. Тэгээд шовхийн орой дээрээс эжийг дуудсанд ээж зам зуураа аргал түүхээр араг үүрээд ирсэн. Ээж өнөөх үнэгний хушууг үзээд

- Жорнойгоод хатчихсан юм байхчив гэхээр нь би

- Цус нь хөлдчихсөн юм байхчив гээд арганд нь хийгээд явуулсан.

Орой нь аав ирж үнэгийг үзээд "Сайхан үнэг юм та 2 зурсан уу? Зурж авдаг юм" гээд намайг дагуулж тэр газар очоод барьж явдаг модоороо зураад ирж байсан юм. Түгээмэл энэ ёсыг эдүгээ монголчууд үнэгний их ов залиг үлдээж байгаагаар тайлбарлаж байна.

5. Монголчууд нас барсан хүнд газар авахдаа оронго гөрөөсний эвэр, очир эсвэл гахайн соёогоор газар зурж авдаг билээ. Гахайн соёогоор зурж авдаг нь гахай соёогоороо газрын үндэс тасалдаг тиймээс ч эзнийг айлгаж, газрын сүлдийг зайлуулж байна (18:54), (23:372) гэж үздэг ажээ.

6. Дээрхтэй холбогдсон эртний агуулгатай нэгэн чухал мэдээг Монголын түүхийн тулгуур сурвалжийн нэг болох Лувсанданзангийн "Алтан товч"-д тэмдэглэн үлдээсэн нь одоогийн газарт зурдаг ёсыг дундад эртний үетэй харьцуулан судлах боломжийг бидэнд өгч байна.

Монголын Муулан хааныг Оннигудын Муулхай ван алж хороосонд Хорчины Шигшүүдэй баатарын хүү Өнөболд ван цэрэглэн, Муулхай ванг долоон дүүгийнх нь хамтаар толгойг нь авч өшөөг авсан ажээ. Энэ явдлын өмнөхөн Баян Үрэмгэр хааныхаа хүүрийг онголсон байх бөгөөд уг сурвалжид:

*"Тавьсаны хойно Үрмэгэр шар ишт хутгаар хааны хүүрийн гадуур газрыг хэмжин зурж онхлов"* (2:169) гэжээ. Энэ нь хааны цогцос анхандаа хүүр байгаад шар ишт хутгаар тойруулж зурснаар сая онгон шүтээн болсон нь илэрхий учраас өнөөгийн монголчуудын үхэгсдийн газар авч зурдаг ёс нь гагцхүү лус савдгаас газар авч, газрын сүлдийг зайлуулж байгаагаас гадна басхүү нас барагчийн хүүрийг шүтээн болгон онголж буй оршуулгын зан үйлийн салшгүй нэг хэсэг ажээ.

Амьтан болон хүний дүрсийг газарт зурж үлдээдэг эдгээр заншил нь бүгдээр газрын эзэн онгонтой холбогдон үүсч байгаа нь аливаа ургамал, амьтан болоод уул, ус бүхэн өөрсдийн эзэдтэй байдаг хийгээд ургамал амьтад нь уул усныхаа эздэд харъяалагдан оршдог гэсэн монголчуудын эртний газар эх шүтлэгтэй холбоотой болно. Дээр дурдсан сурвалж мэдээнүүдийг холбон зангидаж буй адгуус амьтдыг мэдэгч энэхүү уул усны эзний тухай эрт цагийн хүмүүсийн үзэл төсөөлөл нь эдүгээ цагийн нүүдэлчин монголчууд бидэнд ч уламжлагдан хадгалагдсаар байгаа нь монгол ардын зан үйлийн аман зохиолд өдий төдийгөөрөө тусгагдсан байдаг. Үүнийг гэрчлэх ганц нэг жишээ татваас: Дархад анчны цацлын үгэнд

*"Орон хангай минь  
Огторгуй хурмаст тэнгэр минь  
Баян хангай минь  
Ороход олзын минь үүдийг дэлгэрүүлэн өршөө  
Гарахад ганзагыг минь дэлгэрүүлэн өршөө  
Унасанд минь мөчлөөгүй  
Уусанд минь цалгиагүй  
Баян манахан олзыг хайрла"*

Түүнчлэн монголчууд агнасан аливаа ангаа хангай дэлхийн хишиг хэмээн Баян Хангайдаа баярласнаа илэрхийлж, хишиг буянаа үргэлжид хайрлахыг сүслэн залбирдаг. Мөн монголчууд овоонд чулуу нэмэхдээ

*"Овооны эх нь тандаа*

*Олзны эх нь наддаа"* гэдэг. Энэ мэтээр "Ангийн сан", "Манаахан тэнгэрийн тахилга" зэрэг олон зүйлээс иш татаж болно.

Нөгөөтэйгүүр дээр өгүүлсэн зан үйлийн олонх нь тухайн амьтныг авласан эсвэл тэрхүү хүн, амьтны үхэлтэй (төл малтай холбогдсон эхний хоёр мэдээг "Орлуулах ёс"-ны үүднээс хойно тайлбарлана) холбоотой үйлдэгдэж буйг анхааран ажиглаж, нарийн судалгаа хийвээс эрт цагийн хүмүүсийн үхэл, сүнс, хойт ертөнцийн тухай үзэл ойлголт, тэдгээрийн шүтлэг дэх шүтэлцээг мөшгөн тогтоож уудлан илрүүлэхэд басхүү үнэтэй чухал мэдээ, сурвалж болж байна.

Монголчууд авласан ирвэс, хээрээс олсон үнэгний дүрсийг газарт зурж байж авдаг ёс нь эртний хүмүүсийн хад чулуун дээр зурах болсон шалтгааныг бидэнд бага ч болов тодруулан өгч байна.

Бид эртний хүмүүс дээрх агуулгаар хангай дэлхийн гөрөөснөөс авлаваас түүний орыг (сүгийг) уул усны эзэн онгонд заавал зурж үлдээдэг байжээ хэмээн үзэж байна. Хэдийгээр эрт цагийн хүмүүс хангай дэлхийн хишгийг ан амьтнаар авчихаад оронд нь тухайн амьтны сүг дүрсийг л үлдээж байгаа мэт боловч энэхүү ёсыг үйлдсэнээр хойчийн өдөр ангийн тэнгэр, хангай дэлхий олзын үүдээ өгөөмөр нээж, хишиг буянаа хайрласаар байх болно гэсэн давхар бэлэгдэл бүхий үзэл төсөөлөл тэр цагийн хүмүүсийн сэтгэлгээнд ноёлж байсан гэж үзвээс хад чулуун дээрх адгуус амьтны сүг зураг нь бидний өнөөгийн ойлголт дахь хоосон дүрс бус эртний шүтлэг бишрэлийн гүнзгий агуулгатай агнуурын зан

үйлийн салшгүй хэсэг болох нь илэрнэ. Иймээс ч “сүлд”, “сүнс”, “сүг” гэдэг үгсийн “сү” гэсэн язгуур ижил байгаа явдал нь тохиолдлын хийгээд жирийн зүйл бус юм. Магадгүй эрт үед монгол хэлнээс төвд хэлэнд орсон үгсийн нэг байж болох! Доктор С.Дулам монголчуудын хэлбэр дүрсийн бэлэгдлийн тухай судалгаандаа дээрх хэрэглэгдэхүүнүүдтэй ижил агуулга бүхий сонирхолтой нэгэн жишээг татаад “...эртний хүний сэтгэлгээнд юм хийгээд түүний дүрс хоёрыг адилтгадаг өвөрмөц үзэл төсөөлөл байжээ” (7:35) хэмээн тэмдэглэсэн нь өгүүлж буй сүг үлдээх ёсыг баталгаажуулж байна.

Эрт цагийн хүмүүсийн авласан амьтныхаа сүгийг газрын эзэн онгонд чингэж үлдээж байгаа явдал нь тэр цагийн ан агнуурын зан үйлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж үзээд бид энд сүг үйлдэх ёс хэмээн нэрийдэж байгаа болно. Төв Азийн нүүдэлчид авианы бичигтэй болсон хожуу үед ч энэ ёс уламжлан хөгжиж байсныг нотлох мэдээг VIII-X зууны Түрэг, Уйгарын үед холбогдох Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын руни бичгээс (7:219-228) бид урьд уншиж судалсан юм.

VIII-X зууны Түрэг, Уйгарын үед холбогдох Дэл уулын I руни бичээсэнд өгүүлэх “Тэнгэр хан, газар этүгэн минь, уй гашуугүй байлга. Жаран хулан авлав, халтар тэх, тэмээн гөрөөс авлав, хорин чоно авлав” гэсэн мэдээ нь авласан их гөрөөс амьтад тэнгэр хан, газар этүгэн эзнийх болохыг батлахын хамт тэнгэр хан газар этүгэндээ хандсан өчил залбирал нь тэр цагийн агнуурын зан үйлийн салшгүй хэсэг болохыг давхар нотлож байна. Энэ бүхнээс үзвэл бидний өгүүлэн байгаа эртний сүглэх ёсны уламжлал VIII-IX зууны нүүдэлчдийн оюун сэтгэлгээ, ахуй заншилд ч язгуур утгаараа хадгалагдсаар байсныг гэрчилж байна.

Түүнчлэн энэхүү бичээсэнд өгүүлэх “Жаран хулан авлав, халтар тэх, тэмээн гөрөөс авлав, хорин чоно авлав” гэсэн тэр их ав хоморгыг газар этүгэнд тэр тоо ёсоор нь зурж сүглэн үлдээнэ гэдэг бэрхшээлтэй учир соёлын шинэ ололтоо ашиглан бичсэн болох нь илэрхий бөгөөд бас дээр цагийн хүмүүс их олзтой, их ав хоморгоо хэрхэн зурж, тэнгэрт тайлагнадаг байсан бэ гэсэн асуудлыг шийдвэрлэхэд бидэнд ач холбогдолтой нэгэн санааг өгч байна. Учир нь тавин янгир аваллаа гэхэд бүгдийн сүгийг хэрхэн дүрслэх вэ. Энэ нь цаг хугацаа их орох, багаж зэвсэг муутай байх гэхчлэн янз бүрийн шалтгаанаас үүдэн боломжгүй байж болно. Ийм нөхцөлд тавин янгир бус сүргийг төлөөлсөн цөөн тооны тэх, янгир, ишигнүүдийг сүглэн үлдээж болох юм.

### Гурав. Орлуулах ёсны тухай

Бидний судалгаандаа хэрэглэгдэхүүн болгосон сурвалжуудаас бага насны мал халуун нартайд дайрлагт өртөж унах, түүнчлэн ботго, тугалыг төрөнгүүт нь газар тойруулан зурж авдаг ёсыг Оросын эрдэмтэн К.В.Вяткина (8:168) болон манай эрдэмтэн, судлаачид бүтээлүүддээ дурдсан байдаг боловч эртний шившлэг домын ёс гэснээс өөр тодорхой тайлбарыг хийгээгүй ажээ.

Бидний судалгаандаа ашиглаж буй мэдээ баримтуудын олонхи авласан ан, бие барсан хүнтэй холбогдуулж тэдгээрийн сүгийг нь зурж үлдээж байсан бол энд өгүүлж буй хоёр зан үйл нь алж, үхүүлэх бус амьдруулах зорилгоор үйлдэгдэж байгаагаараа бидний дээр өгүүлсэнтэй утгын хувьд эсрэгцэлж байна. Ан амьтныг авлаад газрын онгонд нь сүгийг орлуулдаг байсан эртний ёс мал ахуй амьдралын гол сурвалж болсон хожуу үеийнхний сэтгэлгээнд ингэж эсрэгцэлж дом болон хөгжсөн нь сүглэл буюу сүглэх ёс түүхийн урт хугацааны туршид хэрхэн хөгжиж хувирсныг бидэнд харуулж байна. Сүглэх ёс нь хүмүүс ан агнуур голлон эрхлэж байсан эрт цагт (тухайлбал, хүрэл зэвсгийн үе) газрын эзэн онгоны шүтлэгт шүтэлцэж тогтсон ёс заншил байгаад хожмын мал аж ахуй болоод хүмүүсийн оюуны хөгжлийн явцад эзлэмж нь багасаж зарим нэгэн зан

үйлд хэлбэр төдий үлдэж басхүү заримд нь орлуулах домын хэлбэрээр хувьсаж үлджээ. Ингэж эртний сүглэх ёсны язгуур утгыг эргүүлэн эсрэгцүүлж, сүг үйлдэн домнож мал адгуусаа авч үлдэх гэсэн домын ёсыг бид оршуулгын ёс хэмээн энд бас нэрлэсэн болно.

Өгүүлэн буй орлуулах ёс хүнтэй холбоотойгоор эдүгээ ч монголчуудад уламжлагдсан нь бий бөгөөд үүний тод жишээ бол нэр оршуулах ёс болон нэр солих ёс юм. Энэ ёс нь “алив нэг хүн өвдөж муудан эдгэрэх найдваргүй болоход түүний өмсөж байсан өмд, цамц, оймс зэрэг хувцас хэрэглэл, хамгийн эрхэм эдлэл болон сэвлэгээс нь авч хүн оршуулдаг хэвшсэн зан үйлийн дагуу хөдөөлүүлдэг. Харин өвчтөнөө ор дэвсгэрээс нь сэм шилжүүлэн байрлуулж, шинэ нэрийг өгдөг ёс юм.”

Харин нэр солих ёс нь дээрх зан үйлийг тэр бүр хийдэггүй түүний эдүгээх энгийн болсон хэлбэр нь болно. Энэ ёстой агуулгаараа төстэй зан үйл бурханы шашинд ч дорма хаяулах, донли, золигт гаргах гэхчлэн байх бөгөөд тэдгээр нь бөө мөргөлийн гарвалтай дээрх зан үйлүүдтэй сүлэлдэж, эдүгээ ялгахуй бэрх болжээ.

Түүнчлэн монголчуудын орлуулах ёсны нэг тод түүхэн жишээ бол Өвөр монголын Ордос дахь Их эзэн Чингис хааны онгон болно. Энэ тухай Алтан товчид: Чингис хаан Тангад улсыг сөнөөн дараад гахай жил (1227) Түрэмгий балгасанд тэнгэрт халив. Эзний алтан хүүрийг хасаг тэргэнд тээж харихуйд Мунын хөөвөрт хасаг тэрэг булд хүртэл шигдэж таван хүлгээр татаж хөдөлгөн ядаж, гүр их улс зовоход Сөнидийн Гэлгүдэй баатар өчирүүн:

“... (Халуун амийг чинь алдавч)  
Хас эрдэнэ мэт хүүрийг чинь  
Хамгаалан авч харья эзэн минь  
Хатан Бүртгэлжинд чинь үзүүлэе  
Хамаг улсад чинь хүргэе” гэж өчвөл  
“Хаан эзэн энэрэн соёрхов  
Хасаг тэрэг хангирсан хөдлөө  
Хамаг улс баясгалант болов  
Хан их газарт тэнд хүргэе  
Хамгийн мөнхийг тэнд оршуулж  
Хаан зайсангуудын тулгар болж  
Хамаг улсын шүтээн болоод  
Найман цагаан гэр больё за.  
Энэ их улсад тунхаг зарлаж  
Өмссөн цамц, өргөө гэр  
Ороосон оймсыг тэнд онхлов” (2: 145-146) гэжээ.

Энд өгүүлснээс үзвэл Эзэн Чингисийн алтан хүүр тэнд нилээд саатсаны учир тэрхүү газрын эзэн онгонд түүний өмссөн цамц, ороосон оймс, өргөө гэрийг нь орлуулж үлдээн онголоод, харин хас эрдэнэ мэт цогцсыг өлгий сайхан нутаг руу нь авч одсон байна. Дашрамд, археологийн шинжлэлд “*kenotaphion*” буюу “хоосон булш” хэмээн нэрлэгддэг, монгол орноо түгээмэл тохиолдох, учир шалтгаан, утга агуулгын тайлбар хомс эртний булшуудын хоосон байдгийн учир ч энд өгүүлж буй орлуулах ёсоор тайлбарлагдах боломжтой.

### Гурав: Хөрөг буюу хүн чулууны тухай

Хөрөглөх зан үйл нь сүглэх ёстой утгын язгуур үндэс нэг болох нь. Монгол оронд XX зууны эхний хагасаас Европын соёл өргөнөөр нэвтрэхийн хамт нэг буюу хэд хэдэн хүний дүр төрх, дотоод сэтгэлийг тодруулан зурж дүрсэлдэг, “*portrait*” хэмээх Өрнө дахины дүрслэх урлагийн бие даасан төрөл

зүйлийг "хөрөг зураг" хэмээн эх хэлнээ хөрвүүлэн нэрлэсэн нь эдүгээ нэгэнт хэвшил болжээ.

Угтаа монголчууд өвгөд дээдсээ хальж үгүй болсоны хойно тэднийгээ шүтээн болгон зурсан хийгээд эсгийгээр үйлдсэн, түүнчлэн чулуу цоолборлож урлан бүтээсэн онго дүрсүүдийг хөрөг хэмээн нэрлэдэг уламжлалтай байсан бөгөөд эдүгээ дорнот монголын хүн чулуудыг нутгийнхан хөрөг, мөн буриадын бөө мөргөлтөн, хад чулуун дээр сийлж зурсан, онгон шүтээнийхээ зургийг "усан хаадын хөрөг" (17:184), (5:153) хэмээн нэрлэсээр байгаа нь үүнийг нотолно.

Бидний сайн мэдэх "Чингис хааны эш хөрөг"-ийг Чингис Богдын сүүдэр хальснаас хойш буюу "Юань улсын түүх. Тайлга, тахилгын тэмдэглэл"- д дурьдсан "Их Юаний 15- р он (1278)- ны II сард Тайзунгийн (Чингис хаан) гэгээн дүрийг зурах зарлигийг Хорихасунд тушаав" хэмээсэн баримтыг үндэс болгон судлаачид Хувилай хааны зарлигаар бүтээсэн (4:13) гэж үзсээр ажгуу.

Тэрчлэн хуучны ёс уламжлалаар хүмүүжсэн өтгөс, буурлууд маань өнөө хир нь хөрөг зуруулахаас татгалзаж, "Ямар үхсэн биш дээ" хэмээн цээрлэж цэрэвдэг, түүнчлэн "Нас богиносоно, батиар битгий олон татуулж бай" хэмээн захиж сургамжилдаг нь эртний хөрөглөлийн ёсны эдүгээх нэгэн улбаа төдийгүй басхүү хөрөг хэмээх монгол үгийн язгуур утгыг тодотгон, нотлож буй жишээ болно.

Дундад эртний монголчуудын шүтлэг бишрэл дэх өвгөдийн онго хөргийн талаар сурвалжийн мэдээг нягтлан үзвэл XIII зууны Монголын эзэнт гүрний үед монгол нутагт ирж байсан харийн элч нар нилээд дорвитой мэдээг үлдээжээ. Францын ван IX Людовикийн элч Гильом де Рубрук энэ тухай "Моалууд (Монголчууд) буюу татарууд бол зөвхөн цогцолмол бурханд шүтдэгээрээ тэдний (Юугурын) шашны бүлэглэлд багтдаг боловч нөгчигсдийн дүрсипг эсгийгээр хийж, маш тансаг бөсөөр хувцаслан нэг юм уу, хоёр чингэлэг тэргэнд хийж хадгална. Энэхүү тэргэнд хэн ч хүрч үл зүрхэлнэ. Түүнийг миний хойно ярих тэдний тахилч нар болох зайрангууд сахина. Эдгээр зайран нь Мангу болон бусад баячуудын ордны өмнө этгээдэд байнга сууна." (9:149) гэж өгүүлсэн бол Ромын Папын элч Жиованни дель Плано Карпини "Тэд мөн хаан эзэндээ зориулж онгон шүтээн үйлдээд өргөө гэрийнх нь үүдэн тус газар, мухлаг тэргэн дээр тахиж, маш их өргөл өргөж байхыг бид хааны ордонд байх үедээ харсан билээ." (14:16) хэмээн тэмдэглэн үлдээжээ.

Тэрчлэн Монголын үеийн чулуун хөргүүд, Түрэг, Уйгарын үеийн хүн чулууд болоод хүрлийн үеийн буган чулууд нь тэнгэр болсон өвгөд дээдсэдээ зориулж босгосон онго шүтээнүүд болох нь энэ чиглэлээр судалгаа хийсэн эрдэмтдийн бүтээлүүдээс ажиглагдаж байна. Энэ тухай доктор Д.Баяр "Хүн чулуут цогцолбор босгох нь тэнгэрт халин одсон өндөр өвөг дээдсийнхээ алдар гавъяаг үеийн үед мөнхжүүлэн шүтэх тахил тайлгын чанартай нүүдэлчдийн бөө мөргөлийн шүтлэг бишрэлийн нэгэн хэсэг болно." (5:166) хэмээн үзжээ. Хөрөг хэмээх үгийг Оросын эрдэмтэн Михайлов "Буриадын бөөгийн түүхээс" бүтээлдээ "үзэх харах" гэсэн утгатай түрэг үг (15:184) гэж тайлбарлажээ.

Харин бид үүнийг өөрөөр тайлбарлах саналтай байна. Үүнд: Монголчууд бид орчлонгийн мөнх бусыг үзүүлэн одох өвөг дээдсээ амьсгал хураахуйд зохих ёс, зан үйлийг үйлдээд биеийг нь хөрөхлөөр хүн амьтнаас тусгаарлан буяны ажилд шуурхайлан ордог билээ. Энд бие хөрөх гэдэг нь зүрх зогсож, амьсгал хураасан мөчөөс эсийн түвшин дэх энерги, бодисын солилцоо зогсох хүртэлх биеийн дулаан алдах явцыг хэлж буй хэрэг хийгээд "Бие нь хөрчихлөө" гэж ярьдаг нь тухайн биеийн сүнс сүлд хүний орчлонгоос нэгэнт хальсны шинж хэмээн ойлгож болно. Иймээс хөрөг хэмээх дээр өгүүлсэн дурсгалуудын нэрийг энэхүү хөрөх гэсэн үгтэй холбон тайлбарлаж байгаа болно. Нөгөөтэйгүүр хөшөө хэмээх ерөнхий нэр зөвхөн хөшиж тогтоосон гэсэн утгатай бус басхүү тэнгэрт

хальсан өвөг дээдсийг этүгэн дээр үр хойчис нь орлуулж босгосон, тэгээд ч сүлд сүнс нь үгүй болсон биеийг төлөөлсөн дурсгал гэсэн чинад утгатай байж болно. Энэ тухай бид дараагийн судалгаандаа дэлгэрэнгүй тайлбарлах болно.

Энэ бүхнээс бид өвөг дээдсээ тэнгэр болсоны нь хойно тэднийгээ хөрөглөн онголж шүтэх ёс нь эртний хүмүүсийн ан амьтныг авлан хад чулуунаа сүг үйлдэж үлдээдэг зан үйлтэй утгын язгуур үндэс нэгтэй болохыг иш болгож байгаа төдийгүй, сүг үйлдэх ёс мал аж ахуйн түүхэн хөгжилтэй холбоотойгоор орхигдон гээгджээ. Харин хөрөглөх ёс нь шүтлэг бишрэлийн хөгжлийн явцад букуу хүн байгаль, адгуус амьтныг шүтэх эзлэмж багасаж өвөг дээдсээ шүтэх явдал ихэссэнтэй холбоотойгоор илүү урт хугацаанд хөгжин хувьсаж иржээ хэмээн үзэж байна.

Сүг үйлдэх, орлуулах, хөрөглөх ёс нь утгын язгуур үндэс нэгтэй бөгөөд өөр хоорондоо үүсэл гарвалын хэлхээтэй үзэгдэл болно.

Энэхүү судалгаанд дэвшүүлсэн сүг үйлдэх ёсны үүднээс түүхийн янз бүрийн үед, олон үеийнхний үлдээсэн зураг сүгийн зүйлийг хэрхэн юуны учир бүтээх болсон цаад учир шалтгааныг бүрэн дүүрэн тайлбарлаж чадахгүй боловч хадны зурагт ихэнх хувийг эзлэх адгуус амьтны дүрслэлт зургуудын бүтээгдсэн шалтгааныг тайлбарлахад бидний судалгаа зохих хувь нэмэр болно гэдэгт итгэж байна.

### **The issues of sug**

In this article we touch the problems of why ancient people had been drawn, the pictures of wild animals like deer and wild goat on the rocks and stones which are popular among the "rock pictures".

If not counting the religious letters on the rocks and stones that had been drawn by Mongol during the last 3-4 centuries by the influences of Buddhism, ancient tradition of painting nature and animals on the rocks and stones were forgotten. But some pictures on the ground not on the rocks, which cannot be explained by Buddhism, were left such as pictures related, to nomad's ancient religions, and customs. We did a comparative research by our findings and materials with Mongolian historical documents of the Middle Age.

This article consists of 3 parts.

### **Issue of Sug**

We propose that ancient people leave something (Sug or replacement) for their hunted animals. This is because ancient people identify things with their shapes. Also, belief that if someone leave the shape of his hunted animals on the rocks he would be lucky in the future and God of Hunters will support him is related to this tradition of Sug.

Ancient people's drawn the replacement of their hunted animals on the ground was essential part their hunting customs, so we called this as a tradition of Sug.

### **Tradition of replacement**

We called the tradition that is to protect their (nomad's) animals as opposing to the tradition is used in other customs such as burring custom, Ghinggis Khan's Ongon, and empty tombs.

### **Problems of Horog**

Here we mentioned a tradition of stone statue of the ancient nomads. Traditions Sug, replacement, and Horog have the same routes and their origins are related.

### **Ном зүй**

1. Lobseeldeejia, feldea Dobci, Folegeebegedo\*. 1990 foa
2. Лувсанданзан. *Алтан товч* (Шинэ үсгээр буулгасан Ц.Шагдар), УБ., 1990
3. Бадамхатан С. *Хөвсгөлийн дархад ястан*. УБ., 1965
4. Баяр Д. *Эзэн Чингисийн эх хөрөг*. УБ., 1997

5. Баяр Д. *Монголчуудын чулуун хөрөг*. УБ., 2002
6. БНМАУ-ын угсаатны зүй. боть I.УБ., 1987
7. Болдбаатар Ю. Дэл уулын нэгдүгээр руни бичээс. (mongolica, an international annual of mongol studies), Vol.10(31). УБ., 2000
8. Вяткина К. В. *Монголии МНР*. (Восточно-Азиатский этнографический сборник) М-Л., 1960
9. Гильом де Рубрук .Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988
10. Дамдин Ж. Буурал анчны тэмдэглэл. УБ., 1963
11. Далай Ч. Монголын бөөгийн мөргөлийн товч түүх. УБ., 1959
12. Дорж Д. Новгородова Э. А. Петроглифы монголии. Улан-Батор, 1975
13. Дулам С. Монгол аман зохиол, утга зохиол дахь бэлгэдэл зүйн тогтолцоо (Докторын зэрэг горилсон зохиолын хураангуй) Улаан Үд, 1997
14. Жиованни дель Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988
15. Лувсан С. Монгол анчны тэмдэглэл УБ., 1986
16. Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1987
17. Михайлов Т. М. Из истории Бурятского шаманизма, Новосибирск, 1980
18. Мэнэс Г. 1987 онд Ховд аймгийн Алтап, Үенч сумдын захчин ястны дунд явуулсан угсаатны зүйн хээрийн шинжилгээний тайлан, эх хэрэглэгдэхүүн, УБ, 1987, ШУА-ийн ТХГБС
19. Пэрлээ Х. Хэрлэн хавийн анчдын агнуурын зарим хэв заншлын үлдэц. SE. том III F.5. УБ., 1963.
20. Сампилдэндэв Х. Малчин ардын зан үйлийн уламжлал. УБ., 1985
21. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966
22. Цэвээндорж Д. Хад үзүүрийн зураг. SA. Том.XV, f 1, УБ., 1995
23. Эрдэнэбат У. Монголын нууц товчооны Бодончар-мунхаг нэрийн учир (Монгол-Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээ- 4) Сөүл, 1995